

I ФИЛОСОФИЙН ТҮҮХ

АРГА БИЛГИЙН ТУХАЙ Ч.ДЭМЧИГДОРЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТҮҮНИЙ ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСЛЭЛ

(Эртний ухаан судлал №1)

Н.Хавх

МУИС, Нийгмийн шинжлэх ухааны сургууль

Түлхүүр үг: Арга билиг, 12 жил, 9 мэнгэ, 5 махбодь, 8 суудал, пирамидын хууль, 5 хушуу, арга, билгийн тэмдэг, хас тэмдэг

Дорно дахинд бүхнийг арга, билгийн сэтгэлгээгээр хийдэг хэмээн ярьдаг. Яруу найраг, гүн ухаан, одон зурхай, байшин барилга, уран зураг гээд л. "Арга билиг ертөнцийн эх, "а", "б" номын эх" гэдэг ч үг бий. Дорнын бүх улс үндэстэнд арга, билгийн сургаал бий. Хятадын гүн ухаанд аргыг Ян, билгийг Инь, Япон Солонгост мөн адил, Энэтхэгт аргыг упая, билгийг пражня хэмээдэг аж. Арга билгийн талаар буддын сонгодог гүн ухаан болон түүний тайлбар зохиолуудад өгүүлсэн, тайлбарласан, хэлсэн зүйл их байдаг бололтой. Гэхдээ буддизмд энэ тухай зориуд гарган тавьсан бие даасан судар ном, сургаал онолыг миний бие олж харсан юм үгүй билээ. Энэ нь тийм сургаал, онол байхгүйдээ биш, дорно дахин юм юмаа хийж бүтээдэг тэр ухааныг нийтэд дэлгэн тавьж, өөрсдөд нь хүч чадлыг заяадаг, бусдаас илүү мөнх настай сонгодгийн дээд сонгодог соёл иргэншлийг бий болгодог арга, билгийн сэтгэлгээг далд байлгах гэснийх юм болов уу хэмээх сэтгэл төрдгийг нуух юун. Зүйрлэвээс орчин цагт аливаа улс шилдэг техник технологийг; эртний Хятад оронд гангар шаазан хийх арга ухааныг нууцалж ирсэнтэй адил юм уу даа.

Ер нь ном зохиолд тийм юмыг арга, тийм юмыг билиг гэж хэлсэн бүхнээс хөөж, ер нь арга гэж юу юм бэ, билиг гэж юу юм бэ гэдгийг, товчоор хэлвээс ер нь арга, билгийн ухаан гэж биеэ даасан ухаан байдаг бол тэр нь ямар агуулгатай, бодит ертөнцийн оршин тогтнох зүй тогтлыг хэрхэн тайлбарладаг сургаал юм бэ гэдгийг гарган тавихаас өөр арга зам гэж үгүй болов уу. Монголын соён гэгээрүүлэгч, гүн ухаанч Дандаа хэмээх Ч.Дэмчигдорж

“Эрдэнэт толь хэмээх шастир оршвой” зохиолдоо арга билгийн тухай нэн товч боловч, нэн гүн гүнзгий бүрэн гүйцэт агуулгатай тодорхойлолт өгсөн гэж, өчүүхэн би бодсоор өдий хүрсэн. Тэрээр 1863 онд Өвөрмонголын Засгийн чуулганы Хорчин дундад хошуунд төрсөн. Богд хаант Монгол улс байгуулагдах үйлст өөрийн хувь нэмэр оруулах зорилгоор Ар Монголд ирж, Монгол улсын уламжлалт соёлыг тэр үеийн европын соёл иргэншилтэй холбож шинэчлэх сургаал, үзэл баримтлалыг боловсруулж Богд хаант засгийн газарт өргөн барьсан нь энэ “Эрдэнэт толь хэмээх шастир оршвой” аж.

Арга, билгийн сонгодог тодорхойлолт Энэ тодорхойлолтыг сонгодог гэдгийн учир юу вэ гэхлээр, Дэмчигдоржийн эл тодорхойлолт ямар ч цаг үед ач холбогдлоо алдахааргүй, шинжлэх ухааны аль ч салбарт гүн ухааны арга зүй болохоор тодорхойлолт. Тэрээр өөрийн бүтээлд “Жич наран, саран хийгээд од гараг ба эш эрхтэн хийгээд таван махбод, найман хөлөл хийгээд есөн мэнгэ ба өдөр шөнийн ёсон чөтгөр сахиусны хувилах, улирах ба уул нуруу хийгээд загас мэлхий ба хорхой шоргоолжноос аливаа өвс модонд хүртэл энэ арга, билгийн ёсон үгүй нь үгүй. Энэ цөм өөрөө болсон, илүү дутуугүй хослон барилдсан ёсон мөн тул хэн бээр ч засах эвдэх хийгээд нэмж бууруулж үл чадна. Аргын билгийн ёсон, түүний үндэс нэгэн бөгөөд аргын ёсон хөдлөн буюу билгийн ёсон нам буюу арга үүрд хөдлөж үл болно, билиг үүрд нам байж үл болно.* Арга билгийг түшиж нам болно. Билиг аргыг дагаж хөдөлнө”¹ хэмээсэн байдаг. Тодорхойлтонд орсон санааг, дарааллаар нь гарган тавибаас,

1. Арга билгийн ёс бол ертөнцийн бүх үзэгдэл юмсын түгээмэл зүй тогтолтой гэдгийг “Жич наран, саран хийгээд од гараг ба эш эрхтэн хийгээд таван махбод, найман хөлөл хийгээд есөн мэнгэ ба өдөр шөнийн ёсон чөтгөр сахиусны хувилах, улирах ба уул нуруу хийгээд загас мэлхий ба хорхой шоргоолжноос аливаа өвс модонд хүртэл энэ арга, билгийн ёсон үгүй нь үгүй”.
2. Арга билгийн ёс нь хүний ухамсраас үл шалтгаалан объектив шинжтэй, түүнийг хүн дураараа өөрчлөж, хувиргаад байж үл болно гэдгийг: “Энэ цөм өөрөө болсон, илүү дутуугүйг хослон барилдсан ёсон мөн тул хэн бээр засах эвдэх хийгээд нэмж, бууруулж үл чадна”.

3. Арга, билиг хоёр нь өөр өөрийн гэсэн, арга нь тухайн тогтолцоогоо хувиргах, өөрчлөх, билиг нь түүнийг хадгалах хэвээр байлгах гэсэн эсрэг тэсрэг үүрэгтэй: "Арга, билгийн ёсон түүний үндэс нэгэн бөгөөд аргын ёсон хөдлөх буюу билгийн ёсон нам буюу"

4. Арга, билиг хоёр нь харилцан бие биеэ нөхцөлдүүлнэ: Арга билгийг дагаж нам болно, билиг аргыг дагаж хөдөлнө.

5. Арга, билиг хоёрын нэг нь байхгүй байх авбаас нөгөө нь аливаагийн оршин тогтнох хүчин байхаа больж, харин түүнийг устгана. "Арга үүрд хөдлөж үл болно. Билиг үүрд нам байж үл болно".

1. Арга, билиг хоёрын шинж нэг нь нөгөөдөө шингэн, бие биеэ нөхцөлдүүлэн байж ертөнцийн үзэгдэл юмс оршин тогтноно. "Энэ нь цөм өөрөө бий болсон, илүү дутуугүй, хослон барилдсан ёсон мөн". "Арга билгийг түшин нам болно. Билиг аргыг дагаж хөдөлнө".

Арга, билгийн ёсон ертөнцийн түгээмэл зүй тогтол болох нь "Арга, билгийн ёсон үгүй нь үгүй." Энэ бол зүгээр нэг өгүүлбэр бус, буддын гүн ухааны "би үгүй"-н буюу Нагаржунай багшийн найман үгүйсгэлийн шүтэн барилдлагын оргилын дээдийн дээд оргил, хоосны дээдийн дээд хоосон чанарын томъёолол¹.

Тэнд, төрөх үгүй, түрдэх үгүй, мөнх үгүй, тасархай үгүй, ирэх үгүй, одох үгүй, нэг утгат бус, ангид утгат бус² хэмээх найман үгүйсгэл тус бүр нь төрөх, эс төрөх; түрдэх, эс түрдэх; мөнх, мөнх бус; тасрах эс тасрах; ирэх, эс ирэх; одох, эс одох; нэг утгат, олон утгат; ангид утгат, нэгдмэл утгат; гэж арга билгийн 16 хослол, болон задрах тухай, 16 нь хоёр хоёроор 8 болдог тухай, 8 нь дөрөв, 4 нь хоёр болдог, сүүлчийнх нь "би үгүй" хэмээн томъёолдог аж. Тэгээд түүнийгээ:

¹ Энэхүү номын Уйгаржин монгол бичгийн гар бичмэлийг шинэ үсгэнд буулгахдаа "нэгэнт хөдлөх, нэгэнт нам болох нь" хэмээн үг хэрэглэж, жинхэнэ утга санааг нь бүрхэгдүүлснийг залруулан "Арга үүрд хөдлөж үл болно, Билиг үүрд нам байж үл болно" хэмээн залруулав.

Ч.Дэмчигдорж. Эрдэнэт толь хэмээх шастир оршвой. УБ.1996, 26 дахь тал

* Н.Хавх. Буддын гүн ухааны агуулгын харьцуулсан тайлбар. I. УБ, 2005, 269 дахь тал, зураг №55

² Нагаржуна. Дундат үзлийн ухааны чуулган. УБ, 2002, 61 дэх тал

Би үгүй ба би үгүй бээр бус, би хийгээд
 Би үгүй бээр бусын өгүүлэгдэхүүн нэгээхэн бээр үгүйн¹
 томъёолсон байдаг. Тэр нь угтаан "Би үгүй
 Би үгүйн үгүйн үгүй
 Би үгүйн үгүйн үгүйн үгүй
 Би үгүйн үгүйн үгүйн үгүйн үгүй гэсэн томъёо аж.


"Би"-нь билиг, "Би үгүй"-нь арга бөгөөд дээрх томъёолол нь

"Билиг ч үгүй

Арга ч үгүй

Билиг, арга хоёулаа үгүй

Билиг, арга хоёулаа үгүй нь үгүй буюу билиг арга хоёрын шүтэн барилдлага (ёс)" хэмээн томъёологдсон юм болов уу. Ингэхлээр Ч.Дэмчигдорж гуай арга, билгийг Нагаржунай багшийн найман үгүйсгэл шүтэн барилдлага, хоосон чанартай холбон томъёолжээ гэж бодогдоно. Өрнийн сонгодог гүн ухаан болох диалектикт зөрчлийг бий болгон эсрэг тэсрэгийн нэг талыг нэгдэл, нөгөө талыг нь тэмцэл гэдэг тухай үүний өмнө олонтоо, нэлээд дэлгэрэнгүй тайлбарласан. Зөрчлийн тухай Өрнийн гүн ухааны сургаалын "нэгдэл" хэмээх ойлголт нь буддын гүн ухааны "билиг"; "тэмцэл" хэмээх ойлголт нь буддын гүн ухааны "арга" хэмээх ойлголттой бараг давхцана. Учир нь Гегелийн бий болгосон өрнийн гүн ухааны диалектик сургаал нь буддын гүн ухааны Нагаржунай багшийн үндэслэсэн дундат үзлийн онол сургаалаас эх авсан үүх түүхтэй аж. Гүн ухаантан Ч.Дэмчигдорж гуайн "арга, билгийн ёсон үгүйн үгүй" гэсэн томъёололын арга зүйн үүргийг түүний гаргасан жишээний заримыг тайлбарлахад хэрэглэвээс (зураг№1):




1. I. Дундат үзэл буюу арга, билгийн ёсон
2. II.
3. (←) - арга билгийн ёсоор юмсыг тайлбарлах, дедукц сэтгэлгээ
1. Таван махбод
2. 12 жил (наран, саран)
3. Есөн мэнгэ
4. Найман суудал
5. Амьтан, ургамал, нар, сар

Дорно дахин, түүний дотроос арга, билгийн хийгээд таван махбодын онолыг зурхайн онолын үндэс хэмээдэг аж. Таван махбодын онол нь хоёр янз байх агаад эхнийх нь шороо ус, гал хий, огторгуйг одон зурхайн, мод гал, шороо, төмөр, усыг хар зурхайн таван махбод гэж тус тус нэрлэдэг байна. Ч.Дэмчигдорж хоёр янзын таван махбодыг хоёуланг нь тайлбарласан нь мэдээж. Монгол зурхайд таван махбод, 3 мэнгэ, найман суудал буюу хөлөлийг ёс номын дагуу байрлуулсан "Зурхай хүснэгт"-ийг хүний амьдралын хэмжээсийг тайлбарлахад хэрэглэдэг байна.

Хүснэгт №1¹

буян хишиг	хий морь	чөтгөр	хий морь	буян хишиг	бие	чөтгөр	бие	буян хишиг
эм	салхи	бие	амь	гал	чөтгөр	хорлол	шороо	хий морь
шулам	амь	хорлол	хорлол	эм	шулам	амь	шулам	эм
эм	амь	хорлол	4 ногоон	9 улаан	2 хар	бие	чөтгөр	хий морь
буян хишиг	мод	шулам	3 хөх	5 шар	7 улаан	шулам	төмөр	буян хишиг
бие	хий морь	чөтгөр	8 цагаан	1 цагаан	6 цагаан	эм	хорлол	амь
шулам	хорлол	амь	амь	эм	шулам	хорлол	шулам	эм
бие	уул	эм	хий морь	ус	хорлол	бие	огтор гуй	амь
буян хишиг	чөтгөр	хий морь	чөтгөр	буян хишиг	бие	хий морь	чөтгөр	буян хишиг



Таван махбодын арга, билгийн утга. Хар зурхайн таван махбодын арга, билгийн утгыг зургаар илэрхийлэн гаргаваас (Зураг №2) Усыг арга нь билгээсээ нэн ихээр давамгайлсан, төмрийг арга нь билгээсээ давамгайлсан, шороог арга билиг хоёрын тэнцвэрт тогтолцоо, галыг билиг нь аргаасаа давамгайлсан, модыг билиг нь аргаасаа

¹ Монголын зурхай хүн судлал. УБ, 1990, 20 дахь тал

нэн ихээр давамгайлсан тогтолцоо гэж тус тус уншина, үзнэ. (Таван махбодын тухай III бүлэгт дэлгэрэнгүй тайлбарлах болно). Хүний амьдрал нь сансар, нар, дэлхийн бөмбөрцгийн цөмөөс амьдралын энерги авч, хэмнэлээр (биоритмээр) долоо хоногийн час өдөр, хишиг өдөр, 12 жил, жил орох, 9 мэнгэ, найман суудал (хөлөл) хэмээх биоритм бий. **12 жил** Дорно дахины 12 жилийн он тоолол нь зүгээр нэг 12-оор хуваагдсан он жилүүд бус нар, сарнаас энэ дэлхийн амьтан, ургамал түүний дотроос хүнд орж ирэх амьдралын эрч хүч, энергийн, ер нь амьдралын улиран дэвших давтамж, тухайн тэр хүний зан араншин, үзэл бодол, үйл амьдралын бусдаас ялгарах өвөрмөц онцлогийг бий болгогч он жилүүд:

Тэгээд дотроо час, хишиг өдөр гэсэн 7 хоногийн, мэнгэ, суудал (хөлөл) гэсэн жилийн; жил орох, гарах гэсэн 12 жилийн мөн өдрийн, цагийн, сарын, биоритм буюу амьдралын хэмнэлт он тоолол аж; 13,25,37,49,61,73-ны гэх мэт насанд жил орно. Энэ нь хүний амьдрал, биеийн байдлыг тодорхойлогч гол хүчин зүйл болох оюун ухаан, сэтгэл санаа, бие гурвын шүтэн барилдлага сулрах, ядрах оргил жилүүд. Жил болгон өөр өөрийн гэсэн ерөнхий мах бодтой, тэр жил төрсөн хүний тэр жилийн махбодтой хэмээнэ. Тэр хүний шинж төрх тэр махбодоор тодорхойлогдоно. (Зураг№3)



Зураг№3

Махбодын арга,
билигийн тогтолцоо

Эндээс ивээл, харш ээлтэй, ээлгүй жилийн тайлбар, учир утга гарах байх. Жил бол өөр бусад хүнд бараг дахин давтагдахгүй, тухайн тэр хүнд л насан туршид байх түүний салшгүй шинж чанарыг түүнд бий болгоно, заяана. Энэ бол эх болсон газар шороо, дэлхий, эцэг болсон тэнгэрээс тэр хүнд төрөхөд нь л заяасан, хайрласан шинж. Зурхайн ухаанд "Мич жилтэй хүн бол хамгийн итгэлтэй, өрсөлдөөнтэй улс, ухаантай

самбаатай бүтээлч, хамгийн төвөгтэй асуудлыг ч амархан шийдвэрлэж чаддаг,

ямар ч салбарт амжилт олж чаддаг. Гэхдээ тэд нарыг амархан эргүүлж, үзэл бодлыг нь өөрчилж болно. Юмыг дор нь хийх ба нэхнэ. Хүн бүрийн бодсон төлөвлөснийг эвдэх чадвартай, юманд их эрмэлздэг, оргилуун сэтгэлтэй, эрх дураараа хүмүүс. Юмыг эрүүл ухаанаар сэтгэдэг, ихэнх нь алдартай. Гахай жилтэн бол, нохой жилтэн бол, тахиа жилтэн бол, хонь жилтэн бол, морь жилтэн бол, могой жилтэн бол, луу жилтэн бол, туулай жилтэн бол, бар жилтэн бол, үхэр жилтэн бол, хулгана жилтэн бол," гэж жилээр нь хүн бүрийн насан туршид нь дагалдах шинжийг тогтоон тодорхойлсон байдаг. **Есөн мэнгэ:** 12 жил хүний шинж төрх, амьдралын хэмнэл зэргийг зааж зурах, оноон тодорхойлдогийн хувьд жил, мэнгэ хоёр нэг чигийнх: мэнгэний шинж нь жилийнхээ шинжийн нэлээд хэмжээгээр зангидсан, төвлөрүүлсэн шинж байхаар төсөөлөгднө. Жишээ нь "Нэг ногоон мэнгэ нь эхийн цагаан сүү шиг ариун, хоёр хар мэнгэ нь арга, билиг төгөлдөр..."¹ гэх мэтээр тодорхойлогддо. Хүний биохэмнэл нь оюун ухаан, сэтгэл санаа, бие хэмээх амьдралыг авч явагч гурван чигийн хүчин зүйлийн улиран дэвших зүй тогтолтой. Энэ гурван ойртолт, нэгдлийг "мэнгэ" гээд байгаа юм болов уу гэж бодлоо. Жил орно гэдэг нь энэ гурван чигийн хүчин зүйлийн салалт холдолт яриа байхгүй мөн; Тэрээр хүмүүсийн ажил амьдралд учрах бэрхшээл зовлонгийн дээд цэг. Харин мэнгэ нь голлоно гэсэн ойлголт нь биохэмнэлийн нэгдэлтэй байх үе нь дуусч, тэмцэлтэй, задралтай байх үед орлоо гэсэн утга санааг илэрхийлэх мэт санагддаг. Зүй нь гэхэд хоёр хар мэнгэтэй бичин жилтэй хүний хувьд бол "Арга билиг төгөлдөр" шинж дээд цэгтээн хүрсэн, тэгээд буурах, муудах шатандаа орлоо гэж ойлгогддо. Мэнгэ тус бүр өөрийн жил (Хүснэгт №2) түүнийг дагасан махбодтой (Хүснэгт №3) арга, билигтэй.

Хүснэгт №2²

Мэнгэ	Жил			
9 улаан	Үхэр	Нохой	Хонь	Луу
8 цагаан	Бар	Гахай	Бич	Могой
7 улаан	Туулай	Хулгана	Тахиа	Морь

¹ Монголын зурхай хүн судлал. УБ, 1990, 20 дахь тал

² Энэхүү хүснэгтийг хүснэгт №3-аас хөөж гаргав. Үүний тулд оны дарааллаа 12 жилийн тоололд оруулж дөрөв дахин давтуулна; 1901 он үхэр, 1902 он бар, 1903 туулай гэх мэтээр.


6 цагаан	Луу	Үхэр	Нохой	Хонь
5 шар	Могой	Бар	Гахай	Бич
4 ногоон	Морь	Туулай	Хулгана	Тахиа
3 хөх	Хонь	Луу	Үхэр	Нохой
2 хар	Бич	Могой	Бар	Гахай
1 цагаан	Тахиа	Морь	Туулай	Хулгана

Хүснэгт №3¹

9	8	7	6	5	4	3	2	1
улаан	цагаан	улаан	цагаан	шар	ногоон	хөх	хар	цагаан
1901	1902	1903	1904	1905	1906	1907	1908	1909
1910	1911	1912	1913	1914	1915	1916	1917	1918
1919	1920	1921	1922	1923	1924	1925	1926	1927
1928	1929	1930	1931	1932	1933	1934	1935	1936
1937	1938	1939	1940	1941	1942	1943	1944	1945
1946	1947	1948	1949	1950	1951	1952	1953	1954
1955	1956	1957	1958	1959	1960	1961	1962	1963
1964	1965	1966	1967	1968	1969	1970	1971	1972
1973	1974	1975	1976	1977	1978	1979	1980	1981
1982	1983	1984	1985	1986	1987	1988	1989	1990
1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999
2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008

Энэ хүснэгтээс амьдралын мэнгэ, жилийн янз бүрийн био хэмнэл, давтамж, улиран дэвших зүй тогтлыг тооцоолон гаргаж болно. Мэнгэ тус бүрт харгалзах дөрөв дөрвөн жил нь цаг хугацааны хувьд өнгөрсөн рүүгээ чиг, ирээдүй рүүгээ чиг эцэс төгсгөлгүй давтагдана. Тэгэх тэгэхдээн таван махбодын зүй тогтлоор энэ бүхэн явагдана.

¹ Монголын зурхай хүн судлал. УБ, 1990, 22 дахь тал




Зураг №4
(Мичин жилтний
мэнгэний давтамж)

Мичин жилтэй хүний мэнгэний оны давтамжийг түүний өөрийн нь ерөнхий махбод болох төмрөөс хөөж гаргана. Мичин жилтэн 2 хар, 5 шар, 8 цагаан, 12 жилийн үлдсэн бусад дээр нь мэнгэний давтамжийг дээрх аргаар гаргаж болно. Харин мэнгэний бүтэц нь өөр өөр байна.

Үхэр жилтэн л гэхэд 9 улаан, 6 цагаан, 3 хөх; бар жилтэн 8 цагаан, 5 шар, 2 хар; туулай жилтэн 7 улаан, 4 ногоон, 1 цагаан; луу жилтэн 6 цагаан, 3 хөх, 9 улаан; могой жилтэн 5 шар, 2 хар, 8 цагаан; морь жилтэн 4 ногоон, 1 цагаан, 7 улаан гэх мэтээр жилтэн бүр мэнгэний бүтцийн хувьд өөр өөр байна. Мэнгэнд урт, богино хугацааны өдий, төдий давтамж бий. Нэг махбодтой мэнгэнээс нөгөөд шилжихэд 12 жилийн тухайлбал шороон махбодтой хоёр хар мэнгэнээс,

(1908 он), төмөр махбодтой 8 цагаан мэнгэнд (1920), түүнээс дараачийнхад, түүнээс дараачийнхад шилжихэд арван хоёр, арван хоёр жил болно. Нэг мэнгэ дахин давтагдахад 60 жил, тухайлбал 1944 оны төмөр махбодтой 2 хар мэнгэ 36 жилийн дараа буюу 1980 онд, тэр нь 2016 онд, тэр нь 2052 онд гэх мэтээр давтагдана гэсэн үг. Мэнгэ дотрох жил нэг нь нөгөөгөөр солигдоход 9 жилийн, тухайн тэр мэнгэ дахин давтагдах давтамж 36 жил. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр үхэр жилийн 9 мэнгэ нохой жилийнхэд, тэр нь хонь жилийнхэд, тэр нь луу жилийнхэд, тус бүрт 9, бүгд 36 жил болно гэсэн үг. Махбодууд дор дороо арга, билгийн тогтолцоотой байдаг болохоор мэнгэ нь ч адил байх учиртай. (зураг №5)



Зураг№5

Есөн мэнгэ: түүний геометрийн утгын тухай зурхай хүрдэнд есөн мэргийг тооны хувьд хаашаа ч тоолсон 15 байхаар байрлуулсан байдаг. (Хүснэгт№3-ын гол дахь мэнгэний хүрд) Уг хүрдийг тусгайлан, бусдаас нь салган дор харуулав.

Хүснэгт№4

4 ногоон	9 улаан	2 хар
хөх	5 шар	7 улаан
8 цагаан	1 цагаан	6 цагаан

Хэвтээ нүдээр бол:

$$4+5+2=15$$

$$3+5+7=15$$

$$8+1+6=15$$

Босоо нүдээр бол:

$$4+3+8=15$$

$$9+5+1=15$$


$$2+7+6=15$$

Диагнолаар бол:

$$4+5+6=15$$

$$8+5+2=15$$


Мэнгэний энэ хүрд нь кубын оройнуудад, байрласан 1-9, яг голд нь байрласан 5 гэсэн тооны дараах дарааллаар байрласан (Зураг№6) нэг ёсны хавтгай дээрх дүрс гэж үзэх нэгэн хувилбар байж болох юм. Хүрдэн дэхь тоонууд бол уг кубын 6 тал буюу квадратын, диагналаар хуваагдсан гурвалжингийн өнцгийг холбосон тоо болж хувирна. (Зураг№6)



Зураг №6


$4+9+2=15$ нь квадратын катетийг холбосон;
 $3+5+7=15$ кубын,
 $8+1+6=15$ нь квадратын,
 $4+3+8=15$ нь квадратын,
 $9+5+1=15$ кубын, $2+7+6=15$ квадратын,
 $4+5+6=15$ нь квадратын,
 $8+5+2=15$ нь кубын диагональаар тус тус холбогдсон тоо, тэдгээрийн нийлбэр; хүрдийн гол хэмээх 5 буюу 5 шар мэнгэ нь кубын 6 талын диагональууд болох 6 квадрат огтлолцох цэг; кубын цөм.

Таван шар мэнгэ (5) нь квадратыг бүрдүүлэгч 6 суурь тус бүрд суурилсан 6 пирамидын нэгдсэн буюу шүтэн барилдсан орой аж. 6 пирамидыг кубын орой тэмдэглэсэн тоогоор илэрхийлвээс (Зураг №6): кубын дээд суурьтай 4,9,2,7,5; кубын доод суурьтай 8,1,6,3,5 кубын нүүр суурьтай 8,4,9,3,5 кубын баруун гар талын суурьтай 2,7,1,6,5 гэсэн пирамид. Гэхдээ пирамид бүтнээрээ бус талаараа орой нь нийлнэ; шүтэлцэнэ 4,9,2,7,5 пирамидийн бол 4,9,2,5 гэсэн тал нь; 8,1,6,3,5 гэсэн пирамидын; 8,4,9,3,5 гэсэн пирамидын бол 8,1,6,5 гэсэн




Зураг №7

тал; 2,7,1,6,5 пирамидын бол 2,6,7,5 гэсэн тал пирамидын орой өөр хоорондоо шүтэн барилдах учиртай юм байна. "Шидэт тоо"-ны шүтэлцээнд Зураг№7-ын урьд нүүр, түүний эсрэг ар тал суурьтай пирамид оршдоггүй юм байна. Дээр өгүүлсэн шидэт "шидэт тоон"-д оролцдог 4, оролцдоггүй 2 бүгд 6 пирамидыг тус тусын зургаар харуулваас (Зураг№7)



Зураг №39

дээр дараах дүрстэй байна. (Зураг№39) Квадратын харлуулаагүй буюу тухайлбал 5,2,1,6; квадратын 2,1,6; 5,4,7,2 квадратын 4,7,2; 3,4,9,8 квадратын 4,9,8; 5,8,3,6 квадратын 8,3,6 гэсэн талууд нь "шидэт тоо"-ны тогтолцоонд ордоггүй. Квадратын "Шидэт тоо"-г бий болгодог талуудын тогтолцоог, өөрөөр хэлбэл зураг дээрх голын квадратыг жичд нь салган авч бага зэрэг өөрчлөлт хийхэд зурхайн хүснэгтийн 9 мэнгэний хүрд гарч ирнэ. (Хүснэгт№3-ийг эргэн харна уу) Хэрэв "шидэт тоо"-нд үл оролцдог тал пирамидуудыг нь (9,7,1,3) мэнгэний хүрдэнд оруулан хүрдийг нэг хавтгайд байрлуулан өөрчлөвөөс дараах хэлбэрт орж, түүнээс шидэт тоонд оролцдоггүй талуудыг хасвал хас тэмдэг болон хувирна. (Зураг№9)



Зураг №9

Өрнийнхөн нэн гүн гүнзгий ухааныг бий болгохын тулд Дорныг, түүний дотроос Энэтхэг, Төвдийг зорьж ирсэн түүхтэй. Эйнштейн "Харьцангуй онол"-оо, Гегель диалектик сургаалаа бий болгохын тулд энэтхэгт очин Нагаржунай багшийн дунд үзлийн онолыг судалсан гэж судлаачид үздэг юм билээ. Гитлерийн үеийн Германы эзэнт гүрний онолчид буддын сургаал, онолоос авсан, хэрэглэсэн, түүнийхээ хүчээр эзэнт гүрнээ мандуулсан нь их

гэдэг. Түүний нэг нь ертөнцийн тогтолцооны түгээмэл бөгөөд хамгийн гүний зүй тогтол нэг илрэх хэлбэр болох 9 мэнгэний шүтэн барилдах (Зураг №10) дэхь энэхүү загвар. Уг загварыг эзэнт гүрнийхээ гол одон болгосон юм байна. Тэрхүү одонгийн голд 5-ын тоотой тойрог байна уу, үгүй юу, байхгүй бол арга, билгийн дээдийн дээд нэгдлийг бэлгэдэх нар буруу эргэлттэй хэвтээ арга, билгийн тэмдэг гэсэн тэмдэг байна уу, үгүй юу. Уг нь тийм тэмдэг байвал сүлдний утга учир төгөлдөр байхаар юм. Гэтэл одонгийн голд нь нар буруу эргэлттэй босоо хас тэмдэг байхаар юм байна. Хасыг арга билгийн нэгэн хувилбар хэмээдэг болохоор одонгийн голд нь байна гэсэн үг. Харин тийм байна уу, үгүй юу. Гэхдээ хас нь тухай тогтолцооны арга, билгийн бүтцийн хөгжил, өөрчлөлтийн зүй тогтлыг тайлбарладаг байна. Кубын хуулиас хөөн гаргахад арга, билгийн 6 янзын хас тэмдэг байдаг байна. (Зураг №10)

арга, билгийн тэмдгүүд буюу кубын талууд (пирамидууд)							
хас тэмдгүүд							

Зураг №10

Босоо хас тэмдэг нь нар зөв, нар буруу эргэсэн 2 хас тэмдгээс бүтэх ба тэр нь хөгжил нар зөв эргэх, нар буруу эргэх хөдөлгөөнтэй нэгэн зэрэг явагдах зүй тогтолтой гэдгийг илэрхийлнэ. Энэ бүхэн нь эцэс төгсгөлгүй үргэлжлэх зүй тогтол. Өрнийн физик, математик, мөн сонгодог гүн ухаанд ертөнцийн түгээмэл зүй тогтлын нэгэн хувилбар болох пирамидын хуулийн тухай ярьдаг. Куб нь 6 пирамид өөр хоорондоо шүтэн барилдаж бий түгээмлийн дээд түгээмэл хуулийг тайлбарлана. Түүнийг кубын хууль гэнэ. Кубын хууль нь Зураг№8-д харуулсан 6 пирамидын пирамид тус бүрийн дотоод арга билгийн тогтолцоог, уг тогтолцооны өөр хоорондын давхар спиралийг тайлбарлана. Мэрэг төлөгний хүснэгтийн голын хүрд бол кубын хуулийн бүрэн гүйцэд илэрхийлэл биш, дөрвөн пирамидын, гэхдээн тус бүрийн хагас пирамидын зүй тогтлыг л илэрхийлжээ. Мэнгэ тус бүр бусадтайгаа эсвэл тэгш өнцөгт гурвалжингийн катетаар (4,9,2; 8,1,6; 4,3,8; 6,7,2;), эсвэл квадратын диагональаар холбогдоно (4,5,6; 8,5,2;). Катетуудын квадратын нийлбэр нь гипотенузын квадраттай тэнцүү байх адил хажуутай, тэгш өнцөгт гурвалжны хоёр хурц өнцөг нь 45° байх хууль бий. Тэр хуулийн дагуу 9 мэнгэ өөр хоорондоо холбогдох нь холбогдох болов уу. Энэ бүхнийг батлаж нотлоход судалгааг цаашид нарийвчлан хийх шаардлага бий. Ямар ч байсан мэнгэ тус бүр өөрийгөө оролцуулаад 9, бүгд 81 хувилбартай байх аж. (Хүснэгт№4)¹. Хятадын гүн ухаанд (——) -аар аргыг, (— —) -аар билгийг, доод талын зураасаар арга билиг хоёрын аль нь болохыг тогтооно. 7,4,1 хүснэгт дэх мэнгүүд арга тал нь, 9,8,6,5,3,2 хүснэгт дахь билиг тал нь давамгайлсан мэнгүүд гэж уншигдана.

Хүснэгт№5¹

9	8	7	6	5	4	3	2	1	
73	64	55	46	37	28	19	10	1	=====
74	65	56	47	38	29	20	11	2	=====
75	66	57	48	39	30	21	12	3	=====
76	67	58	49	40	31	22	13	4	=====
77	68	59	50	41	32	23	14	5	=====
78	69	60	51	42	33	24	15	6	=====
79	70	61	52	43	34	25	16	7	=====
80	71	62	53	44	35	26	17	8	=====
81	72	63	54	45	36	27	18	9	=====


¹ М.И.Беляев. Милогия. 1999-2001, Вейбсайт. www.yandex.ru. Belyaev m. I. Гармония Ян и инь. 155 дахь тал

Энэ хүснэгтээр билгийн чандахь билгийг (==), аргын чандахь аргыг; тэгээд тэдгээрийн шүтэн барилдлагыг харуулсан хэрэг. 9 мэнгэ нь өөрөө 9 удаа давтагдана; (==) → (==) → (==) → (==) → (==) → (==) гэх мэт давтагдсан нь бас ийм давтамжтай 9 мэнгэтэй шүтэн барилдана. (==) буюу билгийн билгийн (==) → (==) → (==) → (==) → (==) → (==) билиг болох 9 улаан мэнгэ л гэхэд аргын аргын арга болох 1 цагаан мэнгэтэй (73), 2 хар мэнгэтэй (74), 3 хөх мэнгэтэй (75), 4 ногоон мэнгэтэй (76), 5 шар мэнгэтэй (77), 6 цагаан мэнгэтэй (78), 7 улаан мэнгэтэй (79), Найман цагаан мэнгэтэй (80), 9 улаан мэнгэтэй (81) шүтэн барилдан; гэх мэтээр мэнгэ тус бүр 9 удаа, бүгд 81 удаагийн шүтэн барилдлагааг үүсгэнэ. Нэн олон удаагийн давхар, давхар спираль бий болно. Зүйрлэвээс Мендлеевийн үелэх систем лугаа адил. Химийн үелэх хууль ертөнцийн бүх үзэгдэл юмсын хамгийн түгээмэл зүй тогтол болох кубын, куб нь пирамидын хуулийн амьгүй байгальд илрэх нэгэн хэлбэр мөн байх. Кубын хуулийг байгаа байдлаар нь ухааран ойлгоход ердийн хүний сэтгэн бодох ухаанаас давж гарсан ухаан хэрэгтэй аж. Лав л арга, билгийн хуулийг евклидийн хавтгайн геометрийн нэгэн адил нэн эрт дээр үед нирван, нирван шахуу хүний дээд хэмээгдэх оюун ухаанаар бүтсэн хэмээн үздэг хүмүүс байдаг аж.

8 суудал буюу хөлөл Хүн бүрт өөрийн газар нутаг унасан газар, угаасан ус гэж бий адил билгийн тооллын тодорхой жилтэй, тэр жил нь тодорхой махбодтой байх агаад түүнээс үүдэлтэй 8 суудал буюу хөлөл байх аж (Зураг№11). Унасан газар, угаасан уснаасаа төрөнгүүтээ л амьдралын эрч хүч, энергээ авна. Цаашдаа тэндээсээ уг энергийг илүү ихээр сэлбэнэ. Тухайлбал мичин жилд төрлөө гэхэд тэр жилээ дагасан шинж төрхтэй, зан араншинтай, улмаар мэнгэтэй, суудалтай байна. Суудал гэдэг нь угтаан төрсөн жилийн махбод аж. Мич, тахиа төмөрт; нохой огторгуйд (шороонд); гахай, хулгана усанд; бар, туулай модонд; могой, морь галд; үхэр ууланд, (шороонд); луу салхинд (шороо); хонь шороонд; суудалтай гэнэ. (Зураг№11)

1. усан суудал (хулгана, гахай)

2. төмөр суудал (Бич, тахиа)



3. шороо: салхи суудал (Луу)
4. шороо суудал (Хонь)
5. шороо: уул суудал (Үхэр)
6. шороо: огторгуй (нохой)
7. гал суудал: (могой, морь)
8. Мод суудал: (бар, туулай)

Найман жилд нэг удаа өөрийн суудалд сууна.
Бусад долоод нь бусдын суудалд сууна гэсэн үг.

Тухайлбал: 1944 оны модон бичин жил төрсөн хүн бусад жилүүдэд нь өөр суудалд суух бөгөөд 1956 оны гал бичин жил өөрийн суудалд эргэж ирнэ. Өөрийн суудалд сууснаар амьдралын эрч хүч, энерги нь ёс номоороо бүрэн гүйцэт орж ирнэ. Махбодын онолоор бол тэр хүн усан, салхин, шороон буюу арга нь давамгайлсан "өөрийн талын" суудалд суухад амьдралын эрч хүч энерги ёс номоороо орж ирэх хэдий ч өөрийн суудалд суусан байх үеийнхэд хараахан хүрч чадахгүй. Харин тэрээр ууланд, огторгуйд галд буюу билиг нь давамгайлсан "өрөөлийн талын" суудалд суухад амьдралын эрч хүч энерги ёс номоороо орж ирэх хэдий ч уг энерги амьдралд нь хүрэлцэхгүй байх тохиолдол үе үе гарна. "Өрөөлийн суудал"-ыг засна гэсэн ойлголт бас бий. Тэр нь сэтгэл санаагаа аль болохоор түвшин байлгах, аливаад хэзээ хэзээнээс илүү хянуур, нямбай хандах, сэтгэл алдрах, ухаан бодол самгардах, нөхцөл байдлаас аль болохоор зайлсхийх зэргийг хэлж байгаа юм болов уу. Учир нь "өрөөлийн суудал"-д суусан жилүүдэд хувь хүнээс ийм байхыг л шаардана. Суудал засуулахын тулд ном уншуулж, хурал хуруулдаг. Гол нь номондоо бус, уншуулсны дараа өөрийн сэтгэлийг засах, ариутгах, зөөлрүүлэх, ухаанаа төвлөрүүлж, аливаад чамбай, нямбай хандахыг эрмэлзэх явдлын нэр байх. Хүний амьдрал ойролцоогоор 5 жилд өгсөж, дараагийн 5 жилд уруудаж, энэ бүхэн дахин давтагддаг гэж ярьдаг. 5 биш, 4 юмуу, 4.5 ч байж болох юм. Энэ бүхэн "өөрийн талын", "өрөөлийн талын" суудалд суудагтай холбоотой болов уу.

Амьтан, ургамал, нар, сар: Энд зөвхөн загас жараахай, шоргоолж, нар сарны тухай биш, тэдгээрээр төлөөлж амьд хийгээд амьгүй байгалыг бүхэлд нь

авч үзэж, тэдгээр нь арга билгийн тогтолцоо гэдгийг тайлбарласан юм байна гэж ойлгогдоно. Зөрчлийг бий болгогч орчин, организм хоёр; өвсөн тэжээлтэн, махан тэжээлтэн хоёр; удамшил хувьсал хоёр гээд л өөр бусад өдий төдий эсрэг талууд амьтан ургамлын аль алинд нь бий. Тэдгээрийн орчин, өвсөн тэжээлтэн, удамшил нь билгийн; организм махан тэжээлтэн хувьсал нь аргын тал. Нар нь билгийн, сар болон нарны системийн бусад гаригууд нь аргын тал. Учир нь нар төвөөс татна, бусад гариг нь төвөөс зугтана. Нар сар нь хоёулаа нийлээд билгийн тал, дэлхий нь аргын тал. Учир нь "эх болсон газар", "эцэг болсон тэнгэр"; дэлхий дээрх амьдралын эрч хүч, био хэмнэл нар сарнаас орж ирнэ. Дэлхийн амьтан ургамал түүнийг өөр өөрийнхөөрөө хүлээн авч өөр өөрийнхөөрөө амьдарна.

Арга билгийн ёсны объектив хууль, түүнийг зөрчиж үл болох нь Арга билгийн ёсон нь "Цөм өөрөө болсон, илүү дутуугүй хослон барилдсан ёсон мөн тул хэн бээр засах, эвдэх хийгээд нэмж бууруулж үл чадна" хэмээн гүн ухаантан Дэмчигдорж арга, билгийг тодорхойлсон нь нэн гүн гүнзгий утга агуулгатай, тэр нь ертөнцийн түгээмэл зүй тогтлын талаарх өрнийн гүн ухааны сургаал онолтой олон талаар таарч нийцэхээр байна. **"Цөм өөрөө болсон"**, Аливаа хөгжил хөдөлгөөний уг сурвалж шалтгаан нь уг юмын өөрт нь дотоодод нь байдаг. Түүний гадна байдаг гэж үзэх үзэл сонгодог аль ч гүн ухаанд бий; Өрнийн сонгодог гүн ухаанд эхний үзлийг диалектик, хоёрдахийг нь метафизик үзэл гэнэ. Буддын гүн ухаанд эхнийхийг нь дундад үзэл, хоёрдахийг нь тасархайн үзэл гэнэ. Буддын гүн ухаанд аливаа хөгжил хөдөлгөөний шалтгаан өөрт нь байна гэдгийг үйлээр бүтнэ, үйлээрээ үүснэ, хөгжнө, мөхнө, "өөрөө болсон", бүтсэн хэмээн бас томъёолдог. Тэрхүү дотоод шалтгаан нь зөрчил, зөрчил нь өрнийн сонгодог гүн ухаанд нэгдэл, тэмцэл, буддын сонгодог гүн ухаанд арга, билиг хэмээх эсрэг, тэсрэг талуудтай, тэдгээр талууд нь харилцан бие биеэ үгүйсгэхийн хирээр нөхцөлдүүлдэг зүй тогтолтой. Эсрэг талуудын ийнхүү нэг нь нөгөөгөө нөхцөлдүүлэх, үгүйсгэх зүй тогтлыг буддын гүн ухаанд шүтэн барилдлага гэнэ. Гүн ухаантан Ч.Дэмчигдоржийн тодорхойлолтонд "хослон барилдан" гэдэг нь арга, билгийн шүтэн барилдлагааг хэлсэн хэрэг. Сонгодог гүн ухааны хүрээнд яригддаг эсрэг, тэсрэг талууд, арга билиг хоёр

шүтэн барилдах хууль бол ертөнцийн үүсэх, оршин тогтнох, хөгжих, мөхөх түгээмэл зүй тогтол юм. Энэ бол зөрчлийн хууль, зөв сэтгэн бодох ухааны гол агуулга, тийм хууль онол нь сонгодог гүн ухааны онол, салбарын гүн ухааны онол, тодорхой шинжлэх ухааны онол, хар ухааны сургаал гэсэн 4 түвшинд байх тухай үүний өмнө өгүүлсэн Зөрчил, түүнийг бий болгогч эсрэг, тэсрэг талуудын шүтэн барилдлага нь энгийн бие хүн, гарамгай суут, улмаар ухаарлын оргилд хүрчихсэн нирван хүний хүссэн ч хүсээгүй ч бодитойгоор оршиж, тухайн үзэгдэл юмныхаа хөгжил, хөдөлгөөний уг сурвалж болно. Зүй нь гэхэд хэн ч яаж ч бодсон, хүссэн түүнээс үл шалтгаалан нарыг дэлхий тойрсоор, аянга цахилгаан буусаар, жилийн дөрвөн улирал ээлж дугаараараа солигдсоор, хүмүүсийн амьдралд жаргал, зовлон хоёр нэг нь нөгөөгөө халж, солисоор; амьтан төрдгөөрөө төрсөөр, үхдэгээрээ үхсээр, эзэн ажилчин хоёр өөр хоорондоо өрсөлдсөөр, их бага улс үндэсний сонирхол зөрчилдөх үедээ зөрчилдсөөр, нийлэх үедээ нийлсээр байх болно. Ухаарлын оргилд хүрч нирван болно гэдэг энэ бүхнийг танин мэдэхийн дээдээр танин мэдэж, түүний дагуу сэтгэн бодож, түүний дагуу сэтгэлээ залж жолоодож, ердийн хүний ухааны хязгаарыг давж гарч, хязгаарын чанд хүрнэ үү гэхээс ертөнцийн оршин тогтнох хууль зүй тогтол болох арга, билиг шүтэн барилдах ёсыг өөрчилж хувиргаж үл болно, **хуулийг засах, эвдэж, нэмж бууруулж үл чадна**. Аливаа юмс хүнээс, хүний ухамсраас үл шалтгаалан өөрийнхөө дотоод шалтгаан зүй тогтлоороо оршин байхыг объектив шинж хэмээн өрнийн гүн ухаанд томъёолон нэрлэдэг. Түүний яг 180°-ийн эсрэг агуулгатай "субъектив" хэмээх ойлголт байх агаад тэр нь бүх юм хүний ухамсраас шалтгаалж, түүнээс хамаарч оршин байна гэх үзлийг тэмдэглэнэ. Объект, субъект хоёр бодит ертөнцийн объектив хууль, уг ертөнцийн өөрчлөж амьдрах тавилантай төрсөн хүний ухамсарт үйл ажиллагаа хоёр арга, билгийн тогтолцоотой. Түүнийг өрнийн гүн ухаанд объект, субьектийн диалектик, буддын гүн ухаанд арга, билгийн шүтэн барилдлага хэмээнэ. Хүмүүс объектив хуулийг танин мэдэж чадаагүй байх үедээ ч, чадсан үедээ ч байгаль ертөнцийг өөрчлөн хувиргаж, өөрийн хэрэгцээт зүйлийг үйлдвэрлэн, бий болгон амьдарна. Байгаль нийгмийн хуулийг танин мэдэж чадаагүй байх үедээ бас буддын гүн ухааны

хэлээр бол мунхагийн харанхуй буюу нисванист хөтлөгдөн уг хуулийг зөрчнө, эвдэнэ, эсвэл өөрийн төрөлх орчин болох байгаль, хоёрдахь орчин болох нийгэм хоёртой гар хүрэхгүй онгон атар хэвээр нь байлгана. Тэдгээрийг онгон атар чигээр нь байлгах ёстой хэмээн үзвээс тэр нь бас л хуулийг зөрчнө. Энэ нь Ч.Дэмчигдорж гуайн тодорхойлсноор бол арга, билиг хоёр шүтэн. барилдах ёсыг нэмнэ, засна, бууруулна гэсэн үг юм болов уу. Тийм үзэл түүхэнд байсан, одоо ч бий. Өрнийн гүн ухаанд эхнийхийг нь байгаль нийгмийн хуулийг объектив талыг үгүйсгэж, субъектив тал буюу хүмүүсийн ухамсарт үйл ажиллагааны үйлийг туйлшруулсан хоёр дахь үзлийг дээрхийн яг эсрэг, субъект буюу байгаль нийгмийн хуулийн объектив талыг туйлшруулан, субъектив талыг ор тас үгүйсгэсэн хэмээнэ. Эхнийх нь аргын, хоёр дахь нь билгийн туйлшрах; эхнийх нь тасархайн хязгаар волюнтаризм, хоёр дахь нь мөнхийн хязгаар фатализм. Аливаагийн ялангуяа нийгмийн оршин тогтнох үндэс гэвэл арга, билиг хоёрын, объектив, субъектив хоёрын эсрэг тэсрэг талуудын нэгдэл, тэмцэл хоёрын шүтэн барилдлага. (Зураг№12)

1. Арга билиг шүтэн барилдах хуулийн субъектив тал нь, объектив талаасаа, хуульнаасаа түүнийг бууруулах засах эвдэх нь давамгайлж, хүн байгаль нийгмээ эрчимтэй өөрчлөн хувиргах болсон үе.



Зураг№12

2. Арга, билиг шүтэн барилдах хуулийн объектив, субъектив талууд болон хуулийг нэмэх нь бууруулах, засах эвдэхтэй тэнцвэртэйгээр шүтэн барилдаж, хүн байгаль нийгмээ эрчимтэй өөрчлөн хувиргаж, өөрийнхөө хэрэгцээг хангах хэдий ч арга, билиг шүтэн барилдах ёсыг үл зөрчнө. Хүмүүс байгаль

нийгмийн хуулийн объектив талыг хэдий чинээ гүн гүнзгий, бүрэн гүйцэд, төгс төгөлдөр танин мэднэв, түүний хэрээр түүний тэнцвэрийн хуулийг нь зөрчихгүйгээр эрчимтэйгээр өөрчлөн хувиргана. соёл иргэншлээ хөгжүүлнэ.

3. Арга, билиг шүтэн барилдах хуулийн объектив тал нь субъектив талаасаа түүнийг нэмэх нь, бууруулах засах, эвдэхээсээ давамгайлж, хүмүүс байгаль, нийгмээ өөрчлөн хувиргах үйл ажиллагааны эрч хүч, идэвх нь харьсан үе; байгалийг онгон төрхөөр нь өөрчлөн хувиргахгүйгээр байлгах хандлага бий болно. Нийгмийн хөгжил удааширна.

4. Арга, билиг шүтэн барилдах ёс бүрмөсөн алдагдаж, уг ёсыг засах эвдэх нь дагнана. Нийгэм, байгалийн унаган төрх тэр чигээрээ өөрчлөгдөж, хүнийг ч байгалийн ч, нийгмийн ч хувьд экологи аюулд орно. Хөгжил хөгжил биш болж, хэвийн байдлаар ч оршин тогтнож чадахаа болино.

5. Арга буюу эвдэх нь үгүй болсон, билиг буюу нэмэх нь дагнасан; Нийгэм байгаль хоёрт хүмүүс "гараа хүргэхээ" больсон, нийгмийн хөгжил зогсонгид лавширсан; байгаль, газар нутаг тэр чигээрээ атаржсан буюу газар нутгаа тэр чигээр нь дархан цаазтай болгосон байх тохиолдол; байгаль нийгмийн хуулийн объектив тал дагнаж, субъектив тал ор тас үгүйсгэгдэх тохиолдол.

Тухайн тогтолцоонд арга билиг хоёрын гүйцэтгэх үүрэг. Харилцан үгүйсгэл, нөхцөлдүүлэлт, туйлшрал.

Арга, билгийн үндэс нэг. "Арга билгийн ёсон, түүний үндэс нэгэн бөгөөд аргын ёсон хөдлөн буюу, билгийн ёсон нам буюу" Арга, билиг хоёр нь хоёулаа хөгжил, хөдөлгөөний уг сурвалж болох зөрчлийг бий болгон эсрэг тэсрэг талууд, хоёулаа хөгжил, хөдөлгөөний хүчин зүйл энэ утгаараа тэд ижил төстэй, нэг юм. Гэхдээ нэгэн нэгдмэл юмын хоёр тал. Байгалийн шалгарлын хуулиар удамшил, хувьсал хоёр бол амьд биетийн хөгжлийн уг сурвалж, аль аль нь амьд биетийн хөгжлийн хүчин зүйл хоёулаа өөр хоорондоо шүтэн барилдан, тэгсэн атлаа нэг нь нөгөөгөө үгүйсгэнэ. Удамшил нь амьтны хөгжлийн залгамж холбоог бий болгоно. Зүг чигийг нь заана. Хувьсал нь уг хөгжлийн эрч хүч болно. Удамшил нь билгийн тал, хувьсал нь аргын тал. Эхнэр нөхөр хоёулаа тухайн гэр бүлийг авч явагч хүчин зүйлүүд. Эхнэр нь гал, нөхөр нь усан махбодтой байлаа гэхэд өөр хоорондоо нөхөрлөлцөх, дайсагналцах

холбоогоор холбогдоно. Эхнэрийн зүгээс дайсагналцах, нөхрийн зүгээс нөхөрлөлцөх (Зураг№4-г эргэж харна, сумын дагуу дайсагналцана, эсрэгээр нөхөрлөлцөнө) эрч хүч, энерги, үг яриа, оюун ухаан, сэтгэл санаа гарна. Тэдний тэрхүү энерги, үг яриа бодол санаа шүтэн барилдсанаар гэр бүлийн амьдрал зөв замаар урагш ахин давшин дээшилнэ. Эхнэр нөхөр хоёрын гэр бүлийн амьдралд гүйцэтгэх үүргийн үндэс нэг. Аргын ёсон хөдлөн, билгийн ёсон нам зөрчлийг бий болгогч эсрэг, тэсрэг талуудын арга, билиг хэмээх хоёр талын эхнийх нь тухайн тогтолцоогоо хөдөлгөх, өөрчлөх, хөдөлгөөнийг эрчимжүүлэх, хоёр дахь нь тогтвортой, нам тайван байлгах үүрэгтэй. Гэр бүлийн тогтолцоо, харьцаа, амьдралд эцэг эх нь билгийн, үр хүүхэд нь аргын, махбодын тогтолцоонд бол ус нь арга, мод нь билиг; төмөр нь арга, гал нь билиг; дайсагналцах нь арга, нөхөрлөлцөх нь билиг, мэнгэний хувьд бол ус, тэнгэр, салхи нь арга, уул, огторгуй, гал нь билиг. Буддын гүн ухаанд саланги, тусдаа байгаа арга, билиг хоёрыг арга гээд, тэдгээрийн шүтэн барилдлагыг билиг гэнэ. Харьцангуй доод түвшний шүтэн барилдлагыг арга, түүнээс илүү түвшнийхийг нь билиг хэмээнэ. Ямар ч тохиолдолд арга билиг хоёрыг 180° эсрэг хэмээн Ч.Дэмчигдорж гүн ухаантан тайлбарласан нь энэ. Аргын ёсон хөдлөн, билгийн ёсон нам. "Хөдлөх", "нам" байх гэсэн ойлголтын утга нь угтаан 180° эсрэг. Арга билиг хоёр нь 180° эсрэг чиг гэсэн, чухамдаа тэрхүү үгүйсгэл нь тэднийг өөр хооронд нь нөхцөлдүүлнэ, шүтэн барилдуулна. Үүнийг Ч.Дэмчигдорж тодорхойлохдоо **"Арга, билгийг дагаж нам болно, билиг аргыг дагаж хөдөлнө"** хэмээн томъёолсон байдаг. Билгийн шинж аргад шингэн, тэрхүү аргын талыг нам болгоно. Тухайлбал эцгийн, багшийн шинж, амьдралын ухаан туршлага, мэдлэг хүүд, шавьд шингэснээр дээрх шинж, туршлага ухаанаар тэд төлөвшсөнөөр тэдний үзэл бодол, яриа хөөрөө, үйл явдал нь зүг чигээ олно. Тогтуун нам болно. Аргын шинж билигт шингэснээр, тэрхүү билгийн талыг хөргөнө. Зүйрлэвээс, хүүгийн, шавийн шинж, амьдралын эрч хүч энерги, шинийг цаг алдалгүй тусган авах, бодол санаагаа өөрчлөх, хувирах хурд зэрэг нь эцэгт, багшид шингэснээр, нэн нам байдал эс унана. Шинийг мэдрэх, шинээр сэтгэн бодох, шаардлага, эрмэлзлэл тэмүүлэлтэй болно. Хүүгээ, шавиа ойлгох, тэднийгээ үзэл бодол, сэтгэл санаа, үйл ажлыг

нь залж жолоодох чадвар нь нэмэгдэнэ. Эцэг хүү хоёрын, багш шавь хоёрын үйл ажил бүх чиглэлээрээ өөр хоорондоо шүтэн барилдана. Арга билгийн туйлшралын тодорхойлолтонд **“Арга үүрд хөдлөн үл болно, билиг үүрд нам байж үл болно”** хэмээн томъёолсон байдаг. Хэрэв гэр бүлийн харилцааны аргын талд багталцах хүүгийн бодолд эцэг хүн хөтлөгдвөөс тэр гэр бүл цаг үргэлжийн өөрчлөлт, хувиралтанд унана. Тэр тэнцвэртэй тайван, нам байх юм гэж үгүй болно. Энэ бол арга үүрд хөдлөн байхын жишээ. Гэр бүл хэвийн байдлаар оршин байх нэг талын гол нөхцөл бол **“Арга үүрд хөдлөж үл болох”**, хүүгийн бодолд гэр бүл бүхэлдээ, тэр чигээрээ хөтлөгдөж үл болох явдал аж. Хэрэв гэр бүлийн харилцааны билгийн талд багталцах эцгийн бодолд хүү хөтлөгдөж өөрийн гэх бодол, үзэл санаа, сэтгэлгүй болвоос тэр гэр бүл үүрдийн шахуу зогсонги, царцанги байдалд унана. Энэ бол билиг үүрд нам байхын жишээ. Гэр бүл хэвийн байдлаар оршин байх нэг гол нөхцөл бол **“билиг үүрд нам байж үл болох”**. Эцгийн бодолд хүү тэр чигээрээ, юм юман дээр, хөтлөгдөхгүй байх явдал.

Ном зүй

1. М.И.Беляев. Милогия. 1999 - 2001, Вейбсайт. www.yandex.ru. Belyaev м. I. Гармония Ян и Инь.
2. Ч.Дэмчигдорж. Эрдэнэт толь хэмээх шастир оршвой. УБ, 1996
3. Нагаржуна. Дундад үзлийн ухааны чуулган. УБ, 2002
4. Монгол зурхай хүн судлал. УБ, 1990
5. Н.Хавх. Буддын сурган сэтгэл судлал. Хүмүүжлийн гүн ухаан. УБ, 2006